



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/36

Жаргалтхаан сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 03 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдаж байгаа Сумын аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнийг 2024 оны 04 дүгээр сарын 26, 27-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Сумын аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Отгонбаяр – Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Б.Амгаланбаяр – Нийтийн биеийн тамирын арга зүйч, сургуулийн биеийн тамирын багш

Гишүүд: С.Мөнхдэлгэр - Засаг даргын Тамгын газрын

дарга

Ж.Ариунгэрэл – Соёлын төвийн даргын албан

үүргийг түр орлон гүйцэтгэгч

Э.Эрдэнэхүү- Санхүүгийн албаны дарга

Т.Сүрэнцэцэг – Нийгмийн бодлогын мэргэжилтэн

З.Жанчив - Төсөвт байгууллагын төлбөр тооцоо

хариуцсан мэргэжилтэн

Б.Батзориг – Ерөнхий боловсролын сургуулийн


биеийн тамирын багш

Э.Одгаваа – Иргэний танхимын ажилтан

3. Гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулах төсөв төлөвлөгөө, удирдамжийг боловсруулан батлуулж, тэмцээнийг чанартай зохион байгуулж тайлагнахыг ажлын хэсэг (Н.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА

С.ГАНБАТ



Data (D:) / A4 zahiramj